

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тэсийн-Илч” ХХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Хөвсгөл аймаг  
2023 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatar@audit.gov.mn](mailto:erdenebaatar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд  
Утас: 99042699 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин .....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.1 “Тэсийн-Илч” ХХК ба түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
4. Аудитын тайлан .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
5. Аудитын илрүүлэлт .....	12
5.1 Төлбөрийн акт.....	12
5.2 Албан шаардлага .....	12
5.3 Зөвлөмж.....	12
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газар



“ТЭСИЙН-ИЛЧ” ХХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ А.ГАЛБАДРАХ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.06 № 01/265  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тэсийн-Илч” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Тэсийн-Илч” ХХК-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болсон байна.

### Аудитын гол асуудал

“Тэсийн-Илч” ХХК нь тайланд онд 297.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Тэсийн-Илч” ХХК нь 2022 оны зорилтот түвшний биелэлт 102.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	23,304,041.55	31,088,126.07
1.1.2	Дансны авлага	15,484,358.00	21,190,468.29
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	0.00	5,523,380.00
1.1.6	Бараа материал	56,599,789.50	27,597,721.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	300,000.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	95,688,189.05	85,399,696.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,131,354,612.83	3,317,248,580.68
1.2.2	Биет бус хөрөнгө	18,152,000.00	18,922,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,149,506,612.83	3,336,170,580.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,245,194,801.87	3,421,570,276.68
2.1.1.1	Дансны өглөг	54,998.88	1,000,000.01
2.1.1.3	Татварын өр	5,950,865.65	1,681,425.19
2.1.1.4	НДШ - ийн өглөг	597,256.07	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,603,120.60	2,681,425.19
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,603,120.60	2,681,425.19
2.3.1	Өмч: - төрийн	3,632,203,450.00	3,632,203,450.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	252,570,821.51	256,113,021.51
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	158,653,522.58	633,138,371.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(804,836,112.82)	(804,836,112.82)
2.3.10		0.00	(297,729,878.26)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,238,591,681.27	3,418,888,851.49
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	3,245,194,801.87	3,421,570,276.68

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар		/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
31	Борлуулалтын орлого (цэвэр)	399,435,667.17	410,279,702.04
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	594,562,852.03	647,277,258.30
3	Нийт ашиг (алдагдал)	(195,127,184.86)	(236,997,556.26)
8	Бусад орлого	200,000.00	381,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	57,269,591.00	60,772,322.00
11	Санхүүгийн зардал	86,798.62	57,000.00
12	Бусад зардал	1,000,000.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	284,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(253,283,574.48)	(297,729,878.26)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(253,283,574.48)	(297,729,878.26)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(253,283,574.48)	(297,729,878.26)
24	Орлогын нийт дүн	(253,283,574.48)	(297,729,878.26)

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	3,632,203,450.00	211,418,021.51	95,124,931.00	(251,295,485.29)	3,687,450,917.22
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	63,528,591.58	(553,540,627.53)	(490,012,035.95)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	41,152,800.00	0.00	0.00	41,152,800.00
<b>2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	3,632,203,450.00	252,570,821.51	158,653,522.58	(804,836,112.82)	3,238,591,681.27
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(297,729,878.26)	(297,729,878.26)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	3,542,200.00	474,484,848.48	0.00	478,027,048.48
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	3,632,203,450.00	256,113,021.51	633,138,371.06	(1,102,565,991.08)	3,418,888,851.49

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	443,476,429.99	448,241,339.14
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	442,941,429.99	444,909,259.14
	Бусад мөнгөн орлого	535,000.00	3,332,080.00
1.2	Мөнгөн зарлага (-)	423,030,973.56	435,981,654.62
	Ажиллагчдад төлсөн	152,565,377.54	163,735,000.31
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	46,738,492.16	52,840,836.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	87,593,958.50	65,784,336.00
	Ашиглалтын зардалд төлсөн	55,181,140.26	39,201,781.10
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	41,915,811.00	54,341,447.78
	Татварын байгууллагад төлсөн	33,401,565.48	45,999,253.43
	Даатгалын төлбөрт төлсөн	63,750.00	0.00
	Бусад мөнгөн зарлага	5,570,878.62	14,079,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,532,456.43	12,259,684.52
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,690,320.00	4,475,600.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,690,320.00	4,475,600.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,690,320.00)	(4,475,600.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	10,000,000.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,755,136.43	7,784,084.52
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,548,905.12	23,304,041.55
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,304,041.55	31,088,126.07

**2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Халаалтын орлого	357,967,900	364,952,200	6,984,300	101.95
2	Бохир усны орлого	15,447,700	18,484,600	3,036,900	119.66
3	Түрээсийн орлого	3,960,000	1,350,000	(2,610,000)	34.09
4	Цэвэр усны орлого	14,700,000	25,492,900	10,792,900	173.42
	<b>Нийт орлого</b>	<b>389,420,800</b>	<b>400,074,400</b>	<b>10,653,600</b>	<b>102.74</b>
	<b>Нийт зардал</b>	<b>391,052,856</b>	<b>708,009,600</b>	<b>316,956,744</b>	<b>181.05</b>
1	<b>Цалин хөлс ба нэмэгдэл урамшил</b>	<b>194,710,400</b>	<b>200,037,200</b>	<b>5,326,800</b>	<b>102.74</b>
2	Үнэдсэн цалин	184,312,400	193,055,000	8,742,600	104.74
3	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,320,000	6,732,200	412,200	106.52
4	Тэтгэмж	4,078,000	250,000	(3,828,000)	6.13
5	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,082,000</b>	<b>26,062,400</b>	<b>(1,019,600)</b>	<b>96.24</b>
6	НДШЗ	27,082,000	26,062,400	(1,019,600)	96.24
7	<b>Тогтмол зардал</b>	<b>98,195,700</b>	<b>101,275,600</b>	<b>3,079,900</b>	<b>103.14</b>
8	Гэрэл цахилгаан	45,065,700	45,065,700	-	100.00
9	Түлш халаалт/нүүрс/	53,130,000	56,209,900	3,079,900	105.80
10	<b>Хувьсах зардал</b>	<b>34,525,800</b>	<b>42,061,800</b>	<b>7,536,000</b>	<b>121.83</b>
11	Бичиг хэрэг	700,000	673,900	(26,100)	96.27
12	Тээвэр шатахуун	7,000,000	13,895,500	6,895,500	198.51
13	Нүүрс тээвэр	16,800,000	16,800,000	-	100.00
14	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,358,800	1,313,600	(45,200)	96.67
15	Хог хаягдал зайлуулах зардал	2,000,000	2,000,000	-	100.00
16	БҮТЭЗ	250,000	382,500	132,500	153.00
17	Хоол хүнс	6,417,000	6,996,300	579,300	109.03
18	<b>Нормативт зардал</b>	<b>13,318,000</b>	<b>13,410,900</b>	<b>92,900</b>	<b>100.70</b>
19	Хөдөлмөр хамгаалал	13,318,000	13,410,900	92,900	100.70
20	<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>12,621,200</b>	<b>20,814,500</b>	<b>8,193,300</b>	<b>164.92</b>
21	Урсгал засвар	8,621,200	16,814,500	8,193,300	195.04
22	Сэлбэг хэрэгсэл	4,000,000	4,000,000	-	100.00
24	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>800,000</b>	<b>782,000</b>	<b>(18,000)</b>	<b>97.75</b>
25	Дотоод албан томилолт	800,000	782,000	(18,000)	97.75
26	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ</b>	<b>3,379,000</b>	<b>3,285,600</b>	<b>(93,400)</b>	<b>97.24</b>
27	Аудитын төлбөр	600,000	595,000	(5,000)	99.17
28	Үйлдвэрийн зориулалтаар ус ашигласны төлбөр	350,000	320,000	(30,000)	91.43
29	Усны шинжилгээний төлбөр	200,000		(200,000)	-
30	Тээврийн хэрэгслийн татвар	85,000		(85,000)	-
31	Тээврийн хэрэгслийн даатгал	80,000		(80,000)	-
32	Тээврийн хэрэгслийн агаарын бохирдол	10,500		(10,500)	-
33	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000		(33,000)	-
34	ЭХЗЗ-ийн үйлчилгээний хөлс	1,000,000	1,317,600	317,600	131.76
35	ҮХХ-ийн албан татвар	459,500	574,300	114,800	124.98
36	Газрын төлбөр	80,000	53,100	(26,900)	66.38
37	Программын лиценз Архив	331,000	319,000	(12,000)	96.37
38	Хог хаягдлын хураамж	50,000	50,000	-	100.00
39	Банкны шимтгэл	100,000	56,600	(43,400)	56.60
40	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,420,756</b>	<b>300,279,600</b>	<b>293,858,844</b>	
41	Гамшгаас хамгаалах/ БЭЗ/	1,000,000	1,000,000	-	100.00
42	ЭХ-ийн зардал	1,500,000	295,359,600	293,859,600	
43	ТУЗ-ийн зардал	<b>3,920,756</b>	3,920,000	(0,756)	99.98
	<b>Ашиг алдагдал</b>	<b>1,022,744</b>	<b>(297,729,900)</b>	<b>(298,752,644)</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 “Тэсийн-Илч” ХХК ба түүний үйл ажиллагаа

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлнэ.

Компани нь нийт 25 ажилтантай ба Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан үйлдвэрлэх, түгээх, борлуулах
- Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компани нь 2011 оны 01 дүгээр сарын 07-оос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн тогтоолоор “Тэсийн-Илч” ХХК болон өөрчлөгдсөн байна.

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Компанийн гүйцэтгэх захирлыг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын “Тэсийн-Илч” ХХК -ийн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны тогтоолоор томилсон байна.

Байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 09 дүгээр захирлын тушаалаар томилсон байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн ИТХ болсон байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Тэсийн-Илч” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Тэсийн-Илч” ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр захирлын тушаалаар баталсан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Компани нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагадах аргаар бүртгэж тайлагнадаг.

Санхүүгийн бүртгэлийн программаар Leader программыг ашигладаг ба үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй уялдаагүй мэдээлэл солилцоход хүндрэлтэй, систем дотроо цалин хөлс, урьд оны үлдэгдэл зэрэг мэдээллийг дутуу татаж санхүүгийн тайланг алдаатай илэрхийлж, дахин дахин тооцоолохтой холбогдож нягтлан бодогчид болон бидний ажилд хүндрэл учруулж байна.

Тухайлбал: Өртөг, зардлын хуваарилалтыг бүрэн хийх боломжгүй, гар ажиллагаа ихтэй байна.

"Тэсийн-Илч" ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 176.4 сая төгрөгөөр буюу 5.4 хувиар өсөж 3,421.6 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	23.3	31.1	7.8
Авлага	15.5	21.2	5.7
Бараа материал	56.6	27.6	(29.0)
Үндсэн хөрөнгө	3,131.3	3,317.2	185.9
Биет бус хөрөнгө	18.1	18.9	0.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,245.2</b>	<b>3,421.6</b>	<b>176.4</b>
Өр төлбөр	6.6	2.7	(3.9)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,238.6	3,418.9	180.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,245.2</b>	<b>3,421.6</b>	<b>176.4</b>

Мөнгөн хөрөнгө 7.8 сая төгрөгөөр өсөж 31.1 сая төгрөг болсон.

Дансны авлагын үлдэгдэл 5.7 сая төгрөгөөр өсөж 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27.6 сая төгрөг болж өмнөх оноос 29.0 сая төгрөгөөр буурсан нь 2021 оны жилийн цэцэст 2022 оны эхний хагас жилд түлэх 846.81 тн нүүрсийг 32.3 сая төгрөгөөр худалдан авч татсан байна. Үүнийгээ тус оны эхний хагас жилд зарцуулаад 2022 оны сүүлийн хагас жилд 2023 оны нүүрс худалдан аваагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 185.9 сая төгрөгөөр өссөн нь Орон нутаг хөгжүүлэх сангаас 124.0 сая төгрөгөөр 2МВт тогоо худалдан авсан мөн ЗДТГ-аас халуун ус, гүний худаг 2 үндсэн хөрөнгөн дээр шилжүүлж авсан байна.

### 3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 119 дугаар тогтоолын 6 дугаар хавсралаар "Тэсийн-Илч" ХХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн 02 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 392.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 391.0 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 1.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 400.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 708.0 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан байна. Нийт орлогын гүйцэтгэл 400.1 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 10.6 сая төгрөг буюу 2.7 хувиар их байна. Үүнд: Цэвэр ус болон халаалтын орлого нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 708.0 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 317.0 сая төгрөг буюу 81.0 хувиар илүү байна. Үүнд: 2022 оны 1 дүгээр сарын сарын 10-нд ТУЗ-аар зорилтот түвшин батлуулахдаа элэгдэлийн зардал оруулаагүй батлуулсан. 2022 оны жилийн эцэст зорилтот түвшний гүйцэтгэлд элэгдэлийн зардал орсноос шатлгаалсан байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

дд	Үзүүлэлт	2022			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>				
	Халаалтын орлого /НӨАТ-тай дүн/	358.0	365.0	7.0	101.9
1	Цэвэр усны орлого	14.7	25.5	10.8	173.4
	Бохир усны орлого	15.5	18.5	3.0	119.6
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	389.4	400.1	10.7	102.7
3	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	391.0	708.0	317.0	181.0
4	Татварын өмнөх ашиг	(253.3)	(297.7)	(44.4)	117.5
5	Цэвэр ашиг /алдагдал/	(253.3)	(297.7)	(44.4)	117.5
8	Нийт ажиллагсдын тоо	25	25	-	100.0
9	Нийт цалингийн сан	246.6	257.5	(10.9)	104.4
15	<b>НИЙТ АВЛАГА</b>	15.5	21.2	5.7	136.8
16	<b>НИЙТ ӨГЛӨГ</b>	6.6	2.7	(3.9)	17.4
	<b>Үүнээс: Богино хугацаат</b>	6.6	2.7	(3.9)	17.4

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Тэсийн-Илч” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тэсийн-Илч” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### 4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг бүрэн мэдээллэсэн байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 108.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 101.4 сая төгрөгийн залруулга хийж, 6.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	6.6	3	6.6	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>6.6</b>	<b>3</b>	<b>6.6</b>	<b>100</b>

/сая төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.1 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 0.1 сая төгрөгийн алдааг залрууллаа

Үүнд: Цэцэрлэг сумын “Тэсийн-Илч” ХХК нь тайлант онд үсчний суудал түрээсэлж 1.3 сая төгрөгийн түрээсийн орлого олсон боловч хөрөнгө түрээслүүлсэн 0.1 сая төгрөгийн татвараа бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь 20.2 Албан татвар төлөгчийн дараах албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар тооцож албан татвар ногдуулна " 20.2.1 энэ хуулийн 18.6.1, 18.6.2, 18.6.3, 18.6.7, 18.7-д заасан орлогод 10 хувиар" заалтуудтай нийцэхгүй байна. Иймд татварын өглөгийг 0.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, цэвэр ашгийг 0.1 сая төгрөгөөр бууруулах залруулга хийлээ.

Аудитаар нийт 63.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 0.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 63.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын төсвөөс 0.3 сая төгрөгийн архи, шампанск худалдан авч ажилтнуудад олгосон байна. Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 “байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.” хориглоно гэсэн заалттай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын төсвөөс 0.4 сая төгрөгөөр гар бөмбөгийн тэмцээний хувцас худалдан авахад зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5.“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад" зардал гаргахыг хориглоно гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е–баримт/ баримтгүй 9.4 сая төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг хийхдээ анхан шатны баримтын иж бүрдлийг хангах.

#### 2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, бөөн дүнгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хэмжилт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр, орлого зарлагаар тухай бүр бүртгэх.

#### 3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын зөрүүгийн тайлан бэлтгэж, татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, аргачлал батлах тухай" тушаалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын дагуу татварын зөрүүгийн тайланг бэлтгэж, санхүүгийн тайланд тусгах.

**4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 41.0 сая төгрөгийн 4 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 5.5 сая төгрөг нийт 46.5 сая төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг цаг тухай бүрд нь оруулж хэвших.

**5. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2018 онд болосруулан мөрдөж байгаа нягтлан бодох бодлогын баримт бичиг нь одоогийн мөрдөгдөж буй хууль, журам, тушаалд нь нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө түрээслүүлсэн 0.1 сая төгрөгийн татвараа бүртгэж тайлагнаагүй	1	0.1	1	0.1			1	0.1				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага	Албан тушаалтны тоо		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын төсвөөс гар бөмбөгийн тэмцээний хувцас худалдан авахад зарцуулсан	1	0.4	1	0.4								
Байгууллагын төсвөөс архи, шампанск худалдан авч ажилтнуудад олгосон	1	0.3	1	0.3								
И-баримтгүй гүйлгээ хийсэн	1	9.4					1	9.4				
Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо	1	7.3					1	7.3				

хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, бөөн дүнгээр бүртгэсэн										
Татварын зөрүүгийн тайлан бэлтгэж, татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй	1	-				1	-			
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангаагүй	1	0				1	0			
Нийт	6	17.4	2	0.7		4	16.7			

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллээгүй	1	46.5					1	46.5

**АУДИТЫН ТАЙЛАНГ:  
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

Х.ДИЙМАА

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

Н.БАДАМХАНД

